



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/66

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвлийн аялал жуулчлалын эвент “Хөх сувд-2022” арга хэмжээг зохион байгуулахад орон нутгийн болон бусад эх үүсвэрээс бүрдүүлэн зарцуулах төсвийг хавсралтаар баталсугай.

2. Төсвийг батлагдсан хуваарийн дагуу зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал) нарт зөвшөөрсүгэй.

3. Мөсний баярт оролцох зорилгоор зорчих хөдөлгөөн хийсэн автомашинаас авах хураамжийн орлого болон мөсний баярын үйл ажиллагаанд зарцуулах зориулалтаар байгууллагын нэмэлт төсвийн дансанд төвлөрөх бусад орлогыг зориулалтын дагуу, зохих шийдвэрийг гарган зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т зөвшөөрсүгэй.

4. Төсвийн зарцуулалтын тайланг шуурхай гарган санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг бүрэн ирүүлж ажиллахыг холбогдох төсвийн захирагч нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



ШИДЭРБАЯСГАЛАН